



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/32

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 31.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөх сувд 2022” мөсны баярын эвэнт арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан уг арга хэмжээг зохион байгуулах тохиромжтой байршилд мөсний зузааны хэмжилт хийх, өмнөх жилүүдийн мөсны зузааны түвшинтэй харьцуулах, цаг агаарын төлөв байдлын талаар судалгаа хийж, мөсөн дээр тус арга хэмжээг зохион байгуулах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргаж танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Адьяасүрэн

(Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)

Гишүүдэд:

Б.Нэргүй

(Хатгал тосгоны Далайн захиргааны хяналтын улсын байцаагч)

Ж.Төмөрсүх

(Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын захиргааны дарга)

Н.Буян-Өлзий

(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч)

М.Энхболд

(Хатгал тосгоны Цагдаагийн тасгийн дарга, хошууч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Н.Мягмарсүрэн

(Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын дарга, хошууч)

2. Хэмжилтийг шуурхай зохион байгуулж, мөсөн дээр “Хөх сувд 2022” мөсны баярын эвэнт арга хэмжээг зохион байгуулах боломжтой эсэх талаарх дүгнэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Адьяасүрэн)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН